

**Брагри ёнзин Дамцагдорж (1781-1855)-ийн зохиосон  
Махгалын магтаалын шинжлэл**

Батдэлэгийн СОРОНЗОНБОЛД\*  
Монгол улс, Улаанбаатар,  
Монгол Улсын Боловсролын Их Сургууль

**Received:** Aug 08, 2025 | **Revised:** Dec 23, 2025 | **Accepted:** Dec 26, 2025

*Хураангуй:* Бурхны шашны үзэл ойлголт ёсоор шашныг сахин хамгаална гэсэн ам тангарагтай арван сахиусын нэг нь Махгал буюу Гомбо сахиус юм. Монголчууд Махгал сахиусны олон магтаал зохиосон байдгийн нэг нь Брагри ёнзин Дамцагдорж (1781-1855)-ийн бичсэн “Лам цогт түргэн зохиогч билгүүний итгэлтийн магтаал багш итгэлтийг баясгах хүрхрэл” хэмээх магтаал болно.

Брагри ёнзин Дамцагдорж нь Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу, одоогийн Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Онгийн хийд гэж алдаршсан Гүнджамбалын хийдийн лам, нэрт сэтгэгч, соён гэгээрүүлэгч билээ. Тэрээр хорин гурван боть сүмбүмд 760 гаруй ном зохион туурвисан байна.

"Дамцигдоржийн зохиол бүтээлийг бүхэлд нь авч үзвэл судрын болон тарнийн ухааны гэсэн хоёр ерөнхий чиглэлд хувааж болох бөгөөд судрын ухааны чиглэлээр бичсэн бүтээлийг нь билиг барамидын ухаан, төв үзлийн ухаан, илт номын ухаан, винайн ухаан, анагаах ухаан, ламрим, бас намтар түүх болон бурхад, ихэс дээдэс лам, хутагт хувилгаад, их бүтээлч нарын өлмийг бататгахад зориулсан залбирал, магтаал, ерөөл гэх мэт, тарнийн ухааны чиглэлээр бичсэн бүтээлийг нь тарнийн үндсүүдийн тайлбар, тарнийн ухааны хөтөлбөр, авшиг (ван), даган соёрхол (жинан), багшийг бясалгах арга, ядам болон тэтгэгч сахиусуудыг бясалгах арга, хөтөлбөр, бүтээх арга, тахил, балин, сан, сэржим өргөх зэрэг зан үйлийн ба увдисын аймаг гэх мэт чиглэлд хуваан үзэж болох үндэстэй" (Бямбаа. 2011:33).

---

\* © Б.Соронзонболд  
Email: lu\_sanjaa@yahoo.com

Үүнээс Брагри ёнзин Дамцагдорж "Түргэн зохиогч Махгалын магтаал (ལྷུར་མཛོད་ཡེ་ཤེས་མགོན་པོའི་བསྟོན་པ།), "Гятрууны магтаал"( дག་མཛོལ་བསྟོན་པ།), Төгс буянт шашны өмөг хамба Лувсандоржийн мэргэн, тойн, сайны мөн чанарыг эгшиглэн өгүүлэхийн үүднээс магтсан шүлэг Адистид түргэнээ орогч хэмээх оршивой.(དག་ལྷན་བསྟན་པའི་ཚ་ལག་མཁན་པོ་ལྷོ་བཟང་དོ་རྗེ་དཔལ་བཟང་པོའི་མཚན་ཅན་ལ་མཁས་བཙུན་བཟང་པོའི་རང་བཞིན་དབྱངས་སུ་བརྗོད་པའི་སློན་མཁན་བསྟོན་པའི་རབ་ཏུ་བྱེད་པ་བྱི་རྩལ་སྐྱུར་འཇུག་ཅེས་བྱ་བ་བཞུགས་སོ།།), Цогт жаран хоёр Чакрасамбхара бурхны алдрын магтаал (དཔལ་འཁོར་ལོ་བདེ་མཚོག་ལྷ་དྲུག་ཚུ་ཚ་གཉིས་ཀྱི་མཚན་སྟོན་པ།) зэрэг 10 гаруй магтаал зохиол бичсэнээс бид энэ өгүүлэлд "Лам цогт түргэн зохиогч билгүүний итгэлтийн магтаал багш итгэлтийг баясгах хурхрэл" хэмээх төвөд хэлээр бичсэн Махгалын магтаал зохиолынх нь уран сайхны онцлогийг өгүүлэх болно.

**Түлхүүр үг:** Махгал сахиус, Махгалын магтаал, "га прин буюу Га-ийн эрихэс", Брагри ёнзин Дамцагдорж.

## **Analysis of the Mahagala Praise composed by Bragri yonzin Damtsagdorj (1781-1855)**

**Batdeleg SORONZONBOLD**

*Mongolian National University of Education,  
Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** *One of the ten guardians who vowed to protect Buddhism is Mahagal or Gombo guardian. The Mongolians have composed a sutra in praise of Mahagal guardian, one of which is "Praise to the monk Tsogt, the author of the wisdom of the teacher, the waterfall of the teacher's faith, the waterfall of joy" written by Bragri yonzin Damtsagdorj. Bragri yonzin Damtsagdorj (1781-1855) was a lama of Gundjambalin Monastery, now known as Ongiin Monastery in Saikhan-Ovoo soum, Dundgovi aimag, Gobi Thuzee district, Tusheet Khan aimag, and a famous thinker and enlightener. He compiled more than 760 books in twenty-three volumes. "Considering the whole of Damtsigdorj's writings, they can be divided into two general directions: the science of scripture and the science of tantra. His works written in the field of scripture include the science of Bilig Baramid, the science of Central Thought, the science of the Manifestation of the Dharma, the science of Vinaya, the science of medicine, Lamrim, as well as Biographies and Prayers, Praises, Blessings, etc. dedicated to strengthening the lives of Gods, great lamas, incarnations, and great creators. His works written in the field of tantra can be divided into the areas of explanation of the basics of tantra, the program of tantra science, initiation /van/, Dagan soyorhol /jinan/, the method of*

*meditating the teacher, the method of meditating on yadam and supporting amulets, the program, the method of creating, the ritual of offering, balin, san, and the offering of serjim, and the Uvdis aimag, etc."* (Byambaa. 2011:33) *Bragri yonzin Damtsigdorj Mahagal's praise is based on the 18th century. It was composed in the late 19th century. In this article, we will analyze and describe his Mahagalyan Magtaal poem in order to clarify its artistic features.*

**Key words:** *Mahagal amulet, Praise of Mahagal, "ga 'preng", Bragri yonzin Damtsagdorj.*

## 1. Удиртгал

Монголын буддын утга зохиолын яруу найргийн зонхилох төрөлд ХIY зууны үеэс уламжлан ирсэн магтаалын шүлэг зүй ёсоор орно. Монгол оронд дэлгэрсэн бурхны шашны дунд дэлгэрэлтийн үе буюу Их Юань улсын Өлзийт, Хайсан хүлэг, Буянт хаадын төрийн үед бурхны шашны номыг монгол хэлээр урьж, уншиж байх үеэс бурхдын магтаал шүлгийг яруу сайхнаар туурвин бичих болсон. “Энэтхэг, Төвөд, Монголын буддын утга зохиол залбирал, магтаалын шүлгийн баялаг уламжлалтай юм. Тэрхүү залбирал магтаалын шүлэгт үг, утгын олон зүйл тайлбар хийх уламжлал мөн Энэтхэг, Төвөд, Монголын номын мэргэдийн дунд ихэд дэлгэрчээ. Үе цагийн эрхээр үг утга нь ихэд далдран бүгтэрч, ухахуйяа бэрх болсон ухагдахууныг номхотгон засах шавь олны санаа оюуны байдалд тохируулан тайлбарласаар ирсэн бичгийн мэргэдийн уламжлалаас аливаа зохиолын утга агуулга, уран сайхны онцлогийг бүрнээ мэдэж болно” (Сумьяа, 2002: 83). “Монголчууд ХIY зууны эхэн үе гэхэд бурхны шашны уншлага, урилгын номыг зөвхөн орчуулж байсан төдийгүй төрөлх хэлээрээ магтан дуулах болсон нь буддын утга зохиолын яруу найргийн төрөлд нэгэн шинэ үзэгдэл болсон юм” (Цэрэнсодном, 1997: 319).

Бурхдын магтаалд нэн тэргүүнд тухайн бурхныхаа лагшин биеийн эрдэм, сэтгэл буюу тааллын эрдэм, хэлний буюу зарлигийн эрдэм, үйлс буюу зохионгуйн эрдэм, хүч буюу чадлын эрдмийг магтана. Ингэж тухайн бурхныхаа эрдмийг нээн үзүүлж магтах нь бурхнаа өөрийнхөө сэтгэлийн орон, сүсэг итгэлийн зүрхэн толь, бясалган үзэх мэлмийдээ урьж ирүүлж байгаа хэрэг юм.


Брагри ёнзин Дамцагдоржийн бүтээлийн дотор бурхад болон дээдэс багш нарын магтаал, монгол газрын уул, усны магтаал нэлээд байна. Ялангуяа бурхдын магтаалын өнө удаан түүхэн хөгжлийн явцад буддын утга зохиолд өөрийн хүрээллийг олж, эртнээс уламжилж ирсэн “Махгалын магтаал” нь алдартай юм.

## 2. Судалгааны арга

Бид судалгааны ажилдаа эх бичиг, сурвалжийг задлан шинжлэх аргыг үндсэн зарчмаа болгож хийсний зэрэгцээ утга зохиолын судлалд өргөн ашигладаг шинжлэх ухааны задлаг, нийлэг аргыг түлхүү ашигласан болно.

### 3. Судалгааны үр дүн

Брагри ёнзин Дамцагдоржийн бичсэн “Махгалын магтаал” нь төвөд яруу найргийн толгой холбох аргын нэг болох "Га прин" буюу шүлгийн мөр бүгдийг цагаан толгойн гучин үсгийн дэс дараагаар толгойлж зохиосон есөн бадаг, гучин зургаан шад, нэг мөрөнд таван үгтэй магтаалын шүлэг юм /Зураг 1/. Магтаалын дүр дүрслэл, бэлгэдэл утга, уран сайхны тал нь туурвил зүйн үүднээс Бари ламын бичлэг, найруулгын өвөрмөц онцлогийг бүрэн илтгэх бүтээл болжээ. Ялангуяа зохист аялгууны холбон найруулах ёсыг баримтлан адилтгал, чимгийг чадварлаг ашиглаж, шүлгийн шад, бадгийг яруу сайхан найруулснаараа анхаарал татаж байна.



Зураг 1. Дамцагдоржийн зохиосон Махгалын магтаалын нэг хуудас.

Монголын Бурхан Шашны их сургуулийн номын санд буй барын судрын хуудас.

"Цогт түргэн зохиогч бэлгэ билгийн итгэлтийн магтаал багш итгэлтийг баясгах хүрхрэл оршвой" (ᠴᠣᠭᠲᠤ ᠲᠦᠷᠭᠡᠨ ᠵᠣᠬᠢᠣᠭᠴᠢ ᠪᠡᠯᠭᠡ ᠪᠢᠯᠭᠢᠨ ᠢᠲᠭᠡᠯᠲᠢᠶᠢᠨ ᠮᠠᠭᠲᠠᠯ ᠪᠠᠭᠰᠢ ᠢᠲᠭᠡᠯᠲᠢᠶᠢᠭ ᠪᠠᠶ᠋ᠢᠰᠬᠠ ᠬᠦᠷᠬᠦᠷᠡᠯ ᠣᠷᠰᠬ᠋ᠠᠶᠢ) (ᠳᠠᠮᠴᠠᠭᠳᠣᠷᠵᠢᠶᠢᠨ ᠵᠣᠬᠢᠣᠭᠴᠢ ᠪᠡᠯᠭᠡ ᠪᠢᠯᠭᠢᠨ ᠢᠲᠭᠡᠯᠲᠢᠶᠢᠨ ᠮᠠᠭᠲᠠᠯ ᠪᠠᠭᠰᠢ ᠢᠲᠭᠡᠯᠲᠢᠶᠢᠭ ᠪᠠᠶ᠋ᠢᠰᠬᠠ ᠬᠦᠷᠬᠦᠷᠡᠯ ᠣᠷᠰᠬ᠋ᠠᠶᠢ) //dpal myur mdzad ye shes kyi mgon po la bstod pa bla mgon dgyes ba'i nga ro zhes bya ba bzhugs so//) хэмээх энэ судар нь Брагри ёнзин Дамцагдоржийн намтар дотор 26г-28v талд байна.

Судрын цаасны хэмжээ 54.5x9.5 см, бар эхийн хэмжээ 51.3x6.5 см, мөрийн тоо 6, шаргал муутуу цаасан дээр хар бэхээр төвөд сав үсгээр бичиж, Гүнджамбалин хийдэд модон бараар шаргал муутуу цаасан дээр 1867 онд хэвлэжээ.

Махгал хэмээх нь Их хар гэсэн утгатай санскрит үг бөгөөд Махгал бурхны биеийн өнгө нь хөхөмдөг хар байдаг учир ийнхүү нэрийджээ. Өөр төвөд нэр нь Гомбо, монголоор Их итгэлт, Их хар сахиус ч гэж нэрлэдэг. Махгал бурхан нь бурхан бүгдийн нигүүлсэнгүй сэтгэлийн бэлгэдэл болсон Жанрайсиг бурхны догшин дүр гэж үздэг. Махгал бурхны оршин байдаг газрыг бурхны шашинд Энэтхэгийн Дорждангаас зүүн урд зүгт Дүртэдсилвийцал (үхээрийн сэрүүн цэцэрлэг) хэмээх газар оршин байдаг гэж үздэг. Учир нь энэ газар төвөдийн гэгээнтэн Балдан шавари Махгал бурхны бясалгалыг хийхэд Махгал бодитоор ирж үзэгдсэнд түүний магтаал Нүрээд хэмээх номоо айлдсан байдаг.

Махгал бурхан нь махаяана буюу их хөлгөний шашныг сахин хамгаална гэсэн тангарагтай бурхан юм. Бурхныг дүрслэхдээ зургаан мутартай, нэг нигуур гурван мэлмийтэй, хоёр өлмийтэй, бадрангуй сүр жавхаатай ихэд догшин дүр байдалтайгаар дүрсэлсэн байдаг. Гурван мэлмий нь өнгөрсөн, ирээдүй, одоо цагийг илтэд мэдэх, зургаан мутартаа гавал эрх барьсан нь бурхны зарлигийг бэлгэдсэн, дамар барьсан нь хоосон чанарын дууг дуурсгаж буй, бөхгөр хутга барьсан нь мунхгийн харанхуйг дарах, сэрээ барьсан нь хоосон чанар, цалам барьсан нь алив сайн юмсыг эрхэнд хураах, цустай гавал нь бурхны амгалан хоосныг олсныг илэрхийлдэг.

Монголчууд Махгал бурхныг ихэд хүндэтгэн шүтэж биширч байжээ. “Хубилай хааны үед Дайду хотноо Махгал бурхныг алтаар бүтээж, гэрэлт цагаан суваргат сүмд тусгай дуган барин залж, тэндээ шашны номыг монголоор хурж байв” (Галбаяр, 2010: 178). Энэ уламжлалаар Монголд Махгалын шүтлэг тахилга ихэд түгсэн бөгөөд эдүгээ цагт монголын сүм хийдүүд Махгал сахиусыг хуучдын 29-нд сар болгон тахиж байгаа билээ.

Монголчууд өөрсдийн тахиж шүтэж байсан хангал догшдод зориулж тахилга, магтаал бичиж байсан баримт нэлээд бий. Брагри ёнзин Дамцагдоржийн зохиосон “Лам цогт Нүрээд-Ишийн Гомбын магтаал лам Гомбыг баясгах хүрхрэл” нэрт Махгалын магтаал нь есөн бадаг, гучин зургаан шад шүлэгтэй. Бүтцийн хувьд мөргөлийн үг, заллагын хэсэг, тахил өргөлийн хэсэг, даатгалын хэсгээс бүрдэж байна.

Мөргөлийн үг нь “Намо гүрү маха кала яа (Na mo guru ma h' ka la ya) Багш Махгалад мөргөмүй” хэмээн санскритаар мөргөлийн үгээ хэлсэн нь бурхны ном бүхэн энэтхэгээс эхтэй гэдгийг илэрхийлж буй юм. Магтаалыг эхлэхдээ “Хум” үсгээр эхэлж

байна. Хум үсэг нь Махгал бурхныг төлөөлдөг хөрөнгө үсэг учир Махгал бурхантай холбоотой ном бүхэн Хум үсгээр эхэлдэг байна.

Энэ магтаалын заллагын хэсэг нь таван бадагтай. Нэг дэх бадагт:

*“Hum/ ka dag bde stong nam mkha'i klong yangs nas//  
kha dog nag po'i skur bzhengs bla mgon khyod//  
ga chad ma bor brtse bas nyer dgongs te//  
nga yi snying gi dkyil dbus rol par mdzod//”* гэжээ.

Үүнийг орчуулбал:

*“Угаас арилсан амгалан хоосон огторгуйн төв дундаас*

*Хар өнгөт лагшинд боссон багш Махгал та*

*Гайхшаа барж орхилгүй өрөвдөн таалж*

*Миний зүрхний төв дунд цэнгэ!”* хэмээн зохиогч Махгал бурхныг өөрийнхөө сэтгэлийн орон, сүсэг итгэлийн зүрхний тольтод бясалган үзэх мэлмийдээ урьж ирүүлээд, нэн тэргүүнд лагшингийн эрдмийг нь “хар өнгийн лагшинд боссон” гэж зүс царай, дүр байдлын үүднээс нь магтсан байна. Хоёр дахь бадагт:

*“ca co'i sgra sgrog 'jigs rung 'khor tshogs dbus//*

*cha rdzogs zla ltar gzi ldan mthu bo che//*

*ja sun tsam sogs mchod gtor 'bul gyis bzhes//*

*nya ra mdzad sogs bsrung skyob bka' drin stsol//”* гэсэн бөгөөд үүнийг орчуулбаас доорх мэт.

*“Шуугин дуурсах аймшигт олон нөхдийн дунд*

*Хувь төгс сар мэт сүр төгөлдөр их ахмад*

*Хундага цайны төдий тахил балин өргөхийг таалж*

*Харуулдан орших, сахин аврахын ачийг оршоо!”*

хэмээн Махгал бурхны лагшин биеийн сүр хүчийг “хувь төгс сар мэт сүр төгөлдөр их ахмад” гэж дахин магтаад, улмаар зарлигийн эрдмийг нь “харуулдан орших, сахин аврах” увдистай гэж магтан, балин тахил өргөж буйгаа илэрхийлсэн байна.

Гурав дахь бадагт:

*“ta tha ga ta mi bskyod spyi bor brgyan//*

*tha chung bdag gis bla mar rab bsten ma//*

*da lta nyid du las nyon rtsad gcod nas//*

*na rga la sogs sdug bsngal sel la bstod//”* гэсэн буй.

Орчуулбал:

*“Бурхан Мижодва<sup>43</sup>-г оройгоор чимсэн*

*Адгийн би бээр багшид машид шүтвээс*

*Одоо ямагт үйл нүглийг үндсээр нь таслаад*

<sup>43</sup> Мижодва нь язгуурын таван бурхны нэг

Өвдөх, өтлөх тэргүүтний зовлонг арилгахад магтъя!” хэмээн Махгал бурхан зовлонгийн далайд живэн зовогч амьтанг аварч, ялангуяа хүний төрлийн энэ насны төрөх, өвдөх, өтлөх, үхэх зовлонг арилгадаг хүчтэй гэж түүний тааллын эрдмийг нь магтсан байна. Харин дөрөв дэх бадагт:

*“pa sangs ltar dkar spyan ras gzigs dbang nyid//*

*pha rol ma rungs gdug can dgra bgegs kun//*

*ba mor nyi 'od phog bzhin brlag mdzad phyir//*

*maha ka la'i gar mdzad khyod la bstod//”* гэснийг орчуулан буулгавал:

*“Цолмон мэт цагаан Аръяабал ямагт*

*Чинадын хэрцгий дайсан тотгор бүхнийг*

*Хяруунд нарны гэрэл тусах мэт бүрэлгэн сүйтгэх тул*

*Бүжиглэн зохиох Махгал таныг магтъя!”* хэмээн Махгал бурхны лагшны эрдмийг “цолмон мэт цагаан Аръяабал” гэж дахин өгүүлээд, цааш нь бурхдын үйлсийн эрдэмд багтдаг аюул зовлонгоос амирлуулах, эрхэм дээд номыг дэлгэрүүлэх, харш бүхнийг эрхэндээ хураах, хатуу догшныг буцааж хариулах зохионгуй үйлсийн дөрвөн эрдмийн дотроос аюул зовлонг амарлиулахдаа “хяруунд нарны гэрэл тусах мэт бүрэлгэн сүйтгэх” гэж хатуу үйлсийн эрдмийг магтжээ. Бурхдын үйлсийн эрдмийг амарлиулах, дэлгэрүүлэх, эрхшээх, хатуу гэсэн дөрвөн зүйлд хувааж үздэг.

Цаашлаад удаах бадаг буюу тав дахь бадагт:

*“tsa ru bzang po dgra sha khrag gsol zhing //*

*tsha zer me dbus gar mdzad chos skyong che//*

*dza lang can gyi ri dwags rgyal po yis//*

*wa 'joms bzhin du dam nyams rlog la bstod//”* гэжээ.

Түүнийг орчуулбал:

*“Судас, яс сайн дайсны мамс рагдааг зооглох бөгөөд*

*Халуун гэрэлт галын дунд бүжиглэгч номын их сахиус*

*Муу замд гөрөөсний хаан бээр үнэгийг дарах мэт*

*Тангаргаас буцсаныг сүйтгэгчдийг магтъя!”* хэмээн лагшин, зарлиг, сэтгэл, үйлсийн эрдэм төгссөн Махгал бурхан “муу замд гөрөөсний хаан бээр үнэгийг дарах мэт” тангаргаас буцсаныг дарах чадлын эрдэмтэй хэмээн магтжээ.

Даатгалын хэсэгт дөрвөн бадаг шүлэг байна. Үүнээ лагшин, зарлиг, таалал, үйлс, чадлын эрдмийг цогцлоосон Махгал бурхан бээр амьтан бүхнийг элдэв дайсан тотгор, аюул зовлон, нийтийн гэм уналаас аврах увдистай хэмээн эхний гурван бадагт өгүүлээд, төгсгөлд нь ном эрдмийн ач тусыг хүртсэний ерөөлийн хэсгийг дурдсан байна. Зургаа дахь бадагт:

*“zhwa ser bstan pa'i rgyal mtshan bslab gsum gyi//*

*za 'og rnam bkra btsugs la bar chod pa'i//*

*'a 'ur sgrogs pa'i dgra bgegs tshar bcad nas//*

*ya mtshan mchog la 'god pa'i nus mthu stsol//*"

*“Шар малгайтны шашны дуаз гурван суртгаалын  
Хоргойг дуртуйлан байгуулахад барцад саад болсон  
Дүржигнэн дуугарах дайсан тотгорыг илчлэн таслаад*

*Гайхамшиг дээдэд байгуулах хүч чадлыг оршоо!”* хэмээн эрхэм зарлиг дахь вилайн гол болсон сахил санваараа амиа золин сахих шагшаабадын суртгаал, бие, хэл, сэтгэлийг алгасал үгүй нэгэн үзүүрт чиглүүлж бясалгах дияаны суртгаал, ертөнцийн бэлгэ чанарыг танин мэдэж, авч огоорохыг мэдэгч билгийн суртгаал гэсэн гурван суртгаалыг байгуулахад барцад саад болсон дайсан тотгорыг дарах хүч чадал оршоохыг даатгасан байна. Дараагаар нь:

*“ra med lam ston bla ma'i sku tshe'i dgra//*

*la sogs bar chad mi mthun phyogs rnam zhi//*

*zha tsha'i snying rje byang sems tshe bsod rgyas//*

*sa steng skye 'gro dbang du 'du bar mdzod//*"

*“Саадгүй замыг үзүүлэх багшийн биеийн дайсан  
Тэргүүтэн саад үл зохилдох дөрвөн үйлийг амирлуулж  
Халамжит энэрэнгүй бодь сэтгэл нас буяныг дэлгэрүүлж*

*Газар дээрх төрөлхтөн амьтныг эрхэндээ хураан зохио!”* хэмээн үл даган зохилдохуй үйлс буюу амарлин ахуйг үл даган зохилдох хийгээд үлэмж үзэхүйг үл даган зохилдох үйлийг амарлиулж, энэрэнгүй бодь сэтгэл, нас буяныг дэлгэрүүлж, “газар дээрх төрөлхтөн амьтныг эрхэндээ хураан зохиохыг” даатгажээ. Түүнчлэн:

*“ha ha hum hum phata phata drag po'i sgras//*

*ha cang sdig che'i dam nyams dgra bgegs sgrol//*

*a don stong nyid snying rje dbyer med pa'i//*

*a mtshar maha mu dra'i dngos grub stsol//*"

*“Ха ха хум хум пад падын хатуу дуугаар  
Нэн их нүгэлт тангараг буурсан дайсан тотгорыг гэтэлгэ  
"А"-ийн утга хоосон чанар, энэрэнгүй ялгалгүйн*

*Аяа гайхамшигт Махамудра<sup>44</sup>-ын шидийг оршоо!”* хэмээхүйд “пад пад” хэмээх хатуу тарнийн дуугаар чинадсын санаа барилдлага, муусын чадал хийгээд хараал тэргүүтний оньсон хүрд бүгдийг машид даран, дайсан тотгороос гэтэлгэж, хоосон чанарын утгыг онохын бэлгэдлээр Махамудра буюу бурхны шашны тарнийн ёсны оюуны бясалгалын шидийг оршоохыг даатгасан байна.

*“bsam pa dag pas bstod cing gsol btab na//*

*bsam gyis mi khyab thugs rje nyer bskul te//*

*bsam po'i gnas skabs mthar thug don rnam kun//*

*bsam pa ji bzhin 'grub pa'i bkra shis stsol//*"

*“Санаа ариунаар магтаж залбирваас*

---

<sup>44</sup> Аг тарнийн ёсны эрдэм

*Санаж гүйцэшгүй нигүүлсэхүй нь хөдөлж*

*Санасан ахуй үе эцсийн тусууд бүхэн*

*Санасан ёсоор бүтэхийн өлзий оршоо!*” хэмээн Махгал бурхныг бясалгаж магтаж, залбирч тахиж сүсэглэсний ач буянаар нүглийн гэм мөрөөс ангижирч, гэгээрэлд хүрэх, тэгснээрээ сайн хувь болоод бурхны хувийг олох зам мөрд оруулахыг хүсэж даатгасан байна.

Төгсгөлийн үгэнд “үүнийг Лам Гомбо бурхны егүзэрийн дүрст Иш нэрт бээр өөрийн шавь Базаргирдийн сэтгэлд гэнэт ургасныг ариутган үсэгт бичсэний буянаар би тэргүүтэн эх болсон хамаг амьтан бүгд зүг, цаг ахуй үес бүгдэд ламын тааллыг даган барих болтугай (zhes bla ma dpal myur mdzad ye shes kyi mgon bo la bstod pa bla mgon dgyes ba'i nga ro zhes bya ba 'di ni/bla ma mgon po'i rnal 'byor spyod pa'i gzugs brnyan ye shes ming can gyis rang gi slob bu badzra kirti'i yid ngor thol byung du shar ba nyid dag par bgyis te yi ger bris ba'i dge bas bdag cag la sogs ba'i mar gyur sems can thams cad phyogs dus gnas skabs thams cad du bla ma mgon pos rjes su 'dzin bar gyur cig/) хэмээж буй. Энд гарч буй Базаргирди буюу Дорждаг гэдэг нь Дамцагдорж ламын багын нэр болно. Иш нэрт гэдэг нь Брагри ёнзин Дамцагдоржийг төрсөн цагаас нь эхлэн халамжлан хүмүүжүүлж, ном эрдэмд сурган хөтөлж, 24 настай Төвөдөд явах хүртэл нь судар тарнийн номыг зааж байсан Онгийн голын номч ноён хутагт Ишдонилахүндэв юм. Үүнээс үзвэл тус магтаалыг Брагри Дамцагдорж шүлэглэн айлдсаныг түүний багш Иш нэрт багахан засамжлан бичигт тэмдэглэн үлдээсэн болох нь тодорхой байна.

Тус магтаалыг зохиосон он цагийн тухайд сударт дурдсаныг үзүүлбэл: “...yang sku na phra skabs shig tu myur mdzad ye shes mgon po phyag drug pa ka smad sum cu'i bstod pa zhis gsar rtsom mdzad par bla ma rin po che nas yig bcos cung zad mdzad pa 'di ltar ro//”

“... Бас лагшин бага нэг үед түргэн зохиогч билэг билгүүний зургаан мутарт Махгалд гучин үсгийн дарааллаар магтсан шинэ магтаал нэгийг зохиоход лам эрдэнээс үгийг өчүүхэн засварлаж зохиосон нь энэ мэт болой” хэмээн Брагри лам Дамцагдоржийн намтарт тэмдэглэснээс үзэхэд тус магтаалыг тэрбээр арав гаруй насандаа 1790-ээд оны үед зохиосон бололтой.

#### 4. Дүгнэлт

Брагри ёнзин Дамцагдорж “Лам цогт түргэн зохиогч билгүүний итгэлтийн магтаал багш итгэлтийг баясгах хүрхрэл” хэмээх Махгалын магтаалыг төвөд яруу найргийн толгой холбох нэг арга болох "Га прин" буюу шүлгийн мөр бүгдийг төвөд цагаан толгойн гучин үсгийн дэс дараагаар толгойлж зохиосон есөн бадаг, гучин зургаан

шад, нэг мөрөнд таван үгтэй магтаалын шүлгийг зохион туурвижээ. Энэ магтаалыг Брагри лам Дамцагдорж 1790-ээд оны үед арав гаруй нас сүүдэртэйдээ айлдсаныг түүний багш Онгийн голын номч ноён хутагт Ишдонилахүндэв бичигт буулгажээ. Магтаалын дүр дүрслэл, туурвих арга барилыг ажиглахад зохист аялгууны холбон найруулах ёсыг баримтлан адилтгал, чимгийг чадварлаг ашиглаж, шүлгийн шад, бадгийг яруу сайхан найруулсан нь эрдэмт хуврагийн бичлэг, найруулгын өвөрмөц онцлогийг илтгэх бүтээл болжээ.

### Ном зүй

Брагри ёнзин Дамцагдоржийн мэлмий гийсний 230 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний эмхтгэл (2011). Улаанбаатар. [*Bragri yonzin Damtsagdorjiin melmii giisnii 230 jiliin oid zoriulsan Erdem shinjilgeenii emkhtgel* Ulaanbaatar, 2011]

Бүрнээ, Д, Энхтөр, Д. (2006). *Төвөд Монгол толь*. Улаанбаатар, [Burnee, D. Enkhtör, D. *Tövöd Mongol toli*. Ulaanbaatar, 2006]

Бямбаа, Р. (2011). *Монголчуудын Төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл*. Улаанбаатар. [Byambaа, R. *Mongolchuudyn tövöd kheleer tuurvisan mongol khelend orchuulsan nom züin бүртгэл*. Ulaanbaatar, 2011]

Галбаяр, Г. (2010) *Чойжи-Одсэр ба Дөрвөн мутарт Махгалын магтаал" шүлгийн уран сайхны зарим онцлог*. [Galbayar, G. *Choiji-Odser ba Dörvön mutart Makhagalyn magtaal" shülgiin uran saikhny zarim ontslog*, 2010]

Дамцагдорж, Ц. ༄། །དཔལ་མུར་མཛད་ཡེ་ཤེས་ཀྱི་མགོན་པོ་ལ་བརྟོན་བ་ལྔ་མགོན་དབྱེས་བའི་ང་རོ་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ། །

//dpal myur mdzad ye shes kyi mgon po la bstod pa bla mgon dgyes ba'i nga ro zhes

bya ba bzhugs so// Эртний хүрээ модон барын судар

Дагвадорж, Д. (1995). *Монголын шашин суртахууны тайлбар толь*. Улаанбаатар, АУИС-ийн хэвлэлийн товчоо. [Dagvadorj, D. *Mongolyn shashin surtakhuny tailbar toli*. Ulaanbaatar: AUIS-iin khevleliin tovchoo, 1995]

Жанжаа Ролбидорж. (1986). *Мэргэд гарахын орон нэрт дохио бичгийн толь*.

Бээжин: Дундад улсын үндэстний хэвлэлийн хороо. Janjaa Rolbidorj. (1986).

Merged garakhyn oron nert dokhio bichgiin toli. Beejin: Dundad ulsyn ündestnii khevleliin khorov.

Раашцэрэн, (2000). *Оюуныг тодруулагч эрдэнийн эрхи*. Хөх хот: Өвөр монголын хэвлэлийн хороо. Raashtseren, *Oyuyng todruulagch erdeniin erkhi*. Khökh khot: Övör mongolyn khevleliin khoroo, 2000]

**Сонинбаяр, Ш.** (2011). *Гурван цагийн Бурхадын нийтийн дүрс Богд тойн лам Дамцагдоржийн гэгээний намтар хувь сайтны далайд сүсэглэн орох олом хэмээх оршвой*. Улаанбаатар. (Soninbayar, Sh. *Gurvan tsagiin Burkhadyн niitiin durs Bogd toin lam Damtsagdorjiin gegeenii namtar khuvi saitny dalaid süseglen orokh olom khemeekh orshvoi*. Ulaanbaatar, 2011]

**Сумъяа, Д.** (1999) *Бурхадын магтаалын дүрийн хувьсал (Төвд, Монгол Ногоон Дара эхийн магтаалын эх бичиг, сурвалжийн судалгаа)*. Улаанбаатар. [Sumiyaa, D. *Burkhadyн magtaalyn düriin khuvtas (Tövd, Mongol Nогоон Dara ekhiin magtaalyn ekh bichig, survaljiin sudalгаа)*. Ulaanbaatar, 1999]

**Цэрэнсодном, Д.** (1997). *Монголын бурханы шашны уран зохиол*. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар. [Tserensodnom, D. *Mongolyn burkhany shashny uran zokhiol*. Tergüün devter. Ulaanbaatar, 1997]



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>